# НИЙСЛЭЛИЙН
# ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 14 өдөр Дугаар А/279 Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 79 дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 36,460,490 (гучин зургаан сая дөрвөн зуун жаран мянга дөрвөн зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 79 дүгээр сургууль (У.Дугармаа)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 39 ширхэг 36,460,490 (гучин зургаан сая дөрвөн зуун жаран мянга дөрвөн зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 206,000 (хоёр зуун зургаан мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 61,800 (жаран нэгэн мянга найман зуу) төгрөгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Баянзүрх дүүргийн 79 дүгээр сургууль (У.Дугармаа)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА М.БАЯРАА

11505000327

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2021 оны ..09...... дугаар сарын ..11...... өдрийн
......................А/179........ дугаар тушаалын хавсралт

# Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр:Баянзүрх дүүргийн 79-р сургууль

| д/д | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн Үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
| | **Машин тоног төхөөрөмж** | | | | | | | | | | | |
| 1 | Будаа агшаагч | 9 | ш | 1 | 100,217 | 100,217 | 100,217 | 0 | шатсан | актлах | 2000 | 2000 |
| 2 | Оёдлын машин | 8 | ш | 5 | 195,158 | 975,790 | 975,790 | 0 | Ул гацсан ашиглах боломжгүй | актлах | 3000 | 15000 |
| 3 | Суурин компьютер /dell/ | 8 | ш | 1 | 1,100,000 | 1,100,000 | 1,100,000 | 0 | хавтангийн гэмтэлтэй | актлах | 10000 | 10000 |
| 4 | Багшийн зөөврийн компьютер | 6 | ш | 25 | 1,136,580 | 28,414,500 | 28,414,500 | 0 | их хавтан шатсан,cpu гэмтэлтэй | актлах | 5000 | 125000 |
| 5 | Сурагч зөөврийн компьютер | 6 | ш | 1 | 1,046,850 | 1,046,850 | 1,046,850 | 0 | их хавтан шатсан | актлах | 10000 | 10000 |
| 6 | Toshiba зөөврийн компьютер | 9 | ш | 1 | 1,500,000 | 1,500,000 | 1,500,000 | 0 | их хавтан шатсан | актлах | 15000 | 15000 |
| 7 | Dell ort 330n DT процессори 1,6/51/80DVD17Deel | 13 | ш | 1 | 628,099.85 | 628,099.85 | 628,099.85 | 0 | cpu гэмтэлтэй | актлах | 10000 | 10000 |
| 8 | Samsung принтер | 6 | ш | 1 | 199,900 | 199,900 | 199,900 | 0 | халаагч эвдэрсэн засварлах боломжгүй | актлах | 2000 | 2000 |
| 9 | Проектор ASER | 10 | ш | 1 | 715,000 | 715,000 | 715,000 | 0 | Ламп шатсан | актлах | 5000 | 5000 |
| 10 | олон үйлдэлт суурь машин | 9 | ш | 1 | 441,796 | 441,796 | 441,796 | 0 | цахилгааны гэмтэлтэй шатсан засвар авахгүй | актлах | 2000 | 2000 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Лед проектор 159 | 13 | ш | 1 | 1,338,337.28 | 1338337.28 | 1,338,337.28 | 0 | ламп шатсан | актлах | 10000 | 10000 |
| | | | | | | | | | | | | **206000** |
| Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | | | | **36,460,490** | | | | | | |
| Үүнээс: Худалдах хөрөнгө | | | | | | **36,460,490** | - | | | | | |
| Актлах хөрөнгө | | | | | | - | | | | | | |
| Худалдсанаас олох орлого | | | | | | **206,000.00** | | | | | | |
| НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/ | | | | | | **61,800.00** | | | | | | |